



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 02 сарын 06 өдөр

Дугаар А/41

Хэрлэн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, 45 дугаар зүйлийн 45.2.2, 46 дугаар зүйлийн 46.1.4 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2018 онд хэрэгжих Хэрлэн сумын 4 дүгээр багийн өрхийн эрүүл мэндийн төвийг дулааны шугамд холбох ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үүнд:

Дарга:	Ц.Дэмбэрэлсайхан	-Орон нутгийн өмчийн газрын дарга
Нарийн бичгийн дарга:	Н.Үнэнбат	-Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн
Гишүүд:	Б.Содбилэг	-Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын барилгын материал, үйлдвэрлэл, лаборатори хариуцсан мэргэжилтэн

2. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулахыг ажлын хэсгийн дарга /Ц.Дэмбэрэлсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА